Бусдаар бол БОНХЗ шалгуур үзүүлэлт, босго үзүүлэлттэй байсан ОТ-н ерөнхий мониторингийн хөтөлбөрийг хангалттай гэж үзэж байна. ОТ-н БОЯБХШҮТ-нд шалгуур үзүүлэлтүүдийг үнэлэх, шаардлагатай гэж үзвэл аргазүйд өөрчлөлт оруулах, тохиромжтой менежментийн босго үзүүлэлтийг хянаж үзэх, шаардлагатай бол таван жил тутамд хянаж үзэх шаардлага тавьсан байдаг. Зэрлэг амьтдыг хамгаалах нийгэмлэг зарим үзүүлэлтүүдэд өөрчлөлт оруулахыг зөвлөсөн бөгөөд БОНХЗ нь ОТ-г энэ саналыг харгалзан үзэж, цаашид мониторингийн үйл ажиллагаандаа хэрэглэж болох учраас 2021 оны үнэлгээндээ оруулж өгөхийг зөвлөж байна.

Хүний нөөцийн хувьд уурхайд мониторинг, эрсдэлийн менежментийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд хангалттай гэж үзэж байна. Гэрээт байгууллагуудтай хамтран ажиллах зохицуулалт нь тохиромжтой бөгөөд үр дүнтэй гэж үзэж байна.

Хөдөлмөр эрхлэлт, ажлын нөхцөл

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр Хөрөнгө оруулалтын гэрээгээр хүлээсэн гол үүргүүд биелэгдсэн. 2018 оны 12-р сарын 31-ний байдлаар ОТ үйл ажиллаганы хэсэгт ОТ ХХК-ийн үндсэн болон гэрээт компанийн ажилтнуудыг оруулан нийт 16,581 хүн ажиллаж байна. ОТ ХХК-ийн 2,703 ажилтны 93.49% нь монгол (ХөОГ-нд 90%-с багагүй байхаар заасан) бол “75/25 Гэрээт компанийн” 4,977 ажилтны 97.55% нь Монгол улсын иргэд байна (75%-с багагүй байх шаардлага тавьсан байдаг). “60/40 гэрээт компанийн” 8,901 барилгын ажилтнуудын 89.61% Монгол (60%-с багагүй байх шаардлага тавьсан) ажилтнууд байна. Ажиллах хүчин дэх Өмнөговийн иргэдийн тоо тасралтгүй нэмэгдсээр одоо 3,129-д хүрсэн байна. Мөн, нийт ажиллах хүчний 17%-г эмэгтэйчүүд (ОТ ХХК-ийн ажилтнуудын бараг дөрөвний нэг) бүрдүүлж, ОТ төсөлдээр өнөөгийн байдлаар 40 өөр улс орны иргэд ажиллаж байна.

Уурхай дахь ажилчдын байр сууц, амьдрах орчны тохь тух сайжирсаар байгаагийн жишээнд хооллох, амралт чөлөөт цаг өнгөрүүлэх газруудыг сайжруулсан, мөн уурхай өнгө үзэмж сайжирсан зэргийг дурдаж болно. Оюут II кэмпийн байгуулалт дуусах дөхөж байна. Ростерын хуваарийг авч хэлэлцэн, ростерын төрөлд анализ хийх ба үүнээс шалтгаалан урт хугацааны байр орон сууцны шийдлийг гаргана.

ОТ ажилтнуудад зориулсан урт хугацаан дахь байр орон сууцны стратеги дээр одоо ажиллаж байгаа бөгөөд уурхайн талбай болон ханбогд сум, Өмнөговь аймгийн хэмжээнд илүү өргөн хүрээг хамруулсан холимог хувилбарууд яригдаж байна. Төрийн холбогдох албаны хүмүүстэй уулзалт хийж, хамтарч ажиллаж эхэлсэн бөгөөд сум тус бүрийн кэйс дээр ажиллаж, хүн амын шилжин ирэх болон явах хөдөлгөөний удирдлагыг удирдан зохицуулах хувилбаруудыг авч үзэж байна. 2019 оны 2-р улирлын байдлаар Ханбогдын мастер төлөвлөгөөг шинэчлэх, Стратеги боловсруулахад тулгуур болгон ашиглах нийгэм эдийн засгийн суурь судалгааны ажлууд үргэлжилсээр байна.

Ажилтнуудыг ажиллах нөхцөл болон ажлын гүйцэтгэлийг үнэлэх урамшуулах хөтөлбөрүүд хэрэгжсээр байна. 2019 оны 1-р сараас эхлэн ОТ Бидний бахархал ажилтнуудыг урамшуулах хөтөлбөр эхэлсэн бөгөөд нийт ажилтнуудыг аюулгүй ажиллах орчноор хангах зорилготой Аюулгүй орчин төсөл мөн хэрэгжиж байна. Аюулгүй орчин төслийн хүрээнд согтууруулах ундааны хэрэглээг хязгаарлах; хувь хүний бие махбодийн аюулгүй байдлыг хамгаалах, мэдлэг боловсрол олгох компани ажлууд зохион байгуулах зэрэг арга хэмжээнүүдийг шинээр хэрэгжүүлсэн байна. Бэлгийн дарамт, ахуйн хүрээний хүчирхийллийн эсрэг бодлого шинээр боловсруулж, 2019 оны 9-р сарын сүүлээр хэрэгжүүлж эхлэх ба тэр үед БОНХЗ-д хувийг өгөх болно.

2019 оны 1-р улиралд ОТ ажилтнуудын гомдол санал мэдүүлэх СпийкАут системд нийт 28 санал ирсэн ба ихэнх нь бизнесийн ёсзүйтэй холбоотой асуудал, түүний дараа ажилтнуудтай холбоотой асуудал байсан (мэргэжлээс шалтгаалах өвчний тохиолдол байгаагүй). Эдгээр гомдлыг 30 хоногийн хугацаанд хаах зорилт тавьсан ба дундажаар 21 хоног зарцуулсан.

Нүүлгэн шижлүүлэх, нөхөн олговор өгөх, амьжиргаа сайжруулах

ОТ нүүлгэн шижлүүлэлтийн улмаас эдийн засгийн хувьд нөлөөлөлд өртсөн малчин өрхүүдэд Үр дүнд суурилсан үнэлгээ (ҮДСҮ) хийх зөвлөмж дээр ажиллаж байгаа бөгөөд, нөлөөлөлд өртсөн 89 өрхтэй нэг бүрчлэн уулзаж, зөвлөлдөх ажлыг эхлүүлсэн, 2018 оны хоёрдугаар хагаст Гурван талт зөвлөл (ГТЗ)-д энэ талаар танилцуулсан зэргээр зарим нэг ахиц гаргасан байна. Өрхийн амьжиргаа сайжруулах төлөвлөгөө (ӨАСТ) боловсруулж, ҮДСҮ-р нэмэлт дэмжлэг шаардлагатай гэж тодорхойлогдсон 11 өрхтэй төлөвлөгөөг тохиролцож, 2019 оны нэгдүгээр хагаст гарын үсэг зурсан байна. Хөгжлийн шийдэл ТББ-тай гэрээ хийж, ӨАМГ боловсруулах, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхээр болжээ. ҮДСҮ-р тогтвортой усны эх үүсвэртэй болох шаардлагатай гэж тогтоогдсон таван өрхөд мөн дэмжлэг үзүүлэх арга хэмжээ хэрэгжүүлсэн. Хамтарсан судалгааны дүнд ОТ ус хүргэлтийн үйлчилгээ үзүүлж байсан 3 өрхөд 2019 оны 5-р сарын дундаас эхлэн тус үйлчилгээг зогсоосон бөгөөд үлдсэн хоёр өрхөд худаг барьж өгөх ажлыг дуусгах юм.

Бэлчээр, амьжиргаа сайжруулах менежментийн төлөвлөгөөний гол авах арга хэмжээнүүд болох Ханбогд, Өмнөговь аймгийг хамарсан Орон нутгийн агро бизнесийг дэмжих стратеги төсөл нь 2019-2023 онд Хүнсний чадамжийг хөгжүүлэх стратегийг дэмжих зорилготой. Ханбогд, Баян-Овоо, Баяндалай, Цогт-Овоо сумдын бэлчээр нутгийн үнэлгээ хийж, бэлчээрийн менежментийн ерөнхий тогтолцоог боловсруулсан.

ОТ өрхийн судалгаа, тоо мэдээ бүрдүүлэх, шинэчлэх зэргээр эмзэг бүлгийн өрхийг дэмжих чиглэлээр хэд хэдэн арга хэмжээ авахаар Ханбогд сумтай хамтран ажилласан. Чадавхийг бэхжүүлэх сургалт, иргэдийн оролцоо, нийгмийн харилцааг сайжруулах үйл ажиллагаа хийгдсэн. БОНХЗ нь энэ бүлгийн иргэдэд чиглэсэн ажлыг хэрэгжүүлэхдээ сумын захиргаатай нягт хамтран ажиллаж, Өрхийн амьжиргааг сайжруулах хөтөлбөрт эмзэг бүлгийн иргэдийг зохистой хамруулж буй эсэхийг нягтлах нь чухал гэдгийг тэмдэглэж байна.

Оролцогч талуудтай хамтран ажиллах

ОТ нь оролцогч талуудын байр суурь, хандлагад дүн шинжилгээ хийх зэргээр талуудтай хамтран ажиллах чиглэлээр ихээхэн хүчин чармайлт гаргаж байна. 2019 оны 4-р сар хүртэл зургаан сарын хугацаанд нийт 296 гаруй удаагийн уулзалт, хэлэлцүүлэг хийснээс талаас илүү нь зөвлөлдөх зорилготой байсан бол 13% нь түншлэл хамтын ажиллагааны зорилготой байв. Бараг бүх уулзалтууд эерэг үр дүнтэй болсон гэж тэмдэглэгдсэн байна (96% буюу 10-р сард 84% байснаас сайжирсан байна). Соёлын арга хэмжээ, тэмдэглэлт үйл явдалтай холбоотойгоор нэлээд олон удаа хамтран ажилласан байна.

Мэдээлэл өгөх ажлууд үргэлжилсээр байгаа ба өмнөх үр дүнгүүдээ хадгалсаар байна: жил бүр зохион байгуулдаг Нээлттэй хаалганы өдөрлөг хийж, ОТ болон гэрээт компаниуд Өмнөговийн сонирхогч талуудад Төслийн талаар танилцуулах боломж бүрдсэн. Мөн, ОТ сар тутмын сонинд Төслийн ажлын үр дүнгийн талаар сүүлийн үеийн мэдээллийг тогтмол нийтэлж, тус бүс нутагт нийт 4,400 хувийг тараасан байна.

2018 оны 10-р сараас 2019 оны 5-р сар хүртэлх хугацаанд орон нутгийн иргэдээс нийт зургаан санал гомдол хүлсээж авсан ба тавыг нь зохих хугацаанд нь шийдвэрлэж, барагдуулсан. Гэрээт компани замгүй газраар машинтай явж байгаа холбоотой нэг гомдол шийдвэрлэгдээгүй үлдсэн байна.

Нэг чухал зүйл бол ГТЗ, ХДХЗО-ы хийсэн маргаан шийдвэрлэх процесс эцэслэн дууссан байна. Малчдын өргөдөл гомдлыг шийдвэрлэх гэрээ байгуулах тал дээр 2018 онд ихээхэн ахиц гарсан гэж үзсэн тул ХДХЗО-ы эвлэрүүлэн зуучлах процессыг дуусгавар болгох хамтарсан шийдвэрийг ГТЗ гаргасан. Хамгийн чухал нь ГТЗ-ийн гишүүд ийнхүү энэ процессыг хаасан нь талуудын хооронд бат итгэлцэл тогтсоныг илрэл хэмжээн дүгнэж, хамтын ажиллагаа шинэ шатанд хүрлээ гэж дүгнэсэн. ХДХЗО-ы тайланг олон нийтэд нээлттэй байршуулсан. ГТЗ-ийн стратеги, дүрмийг одоо дахин хянан хэлэлцэж байгаа бөгөөд талууд шинэ үе шатанд хэрхэн хамтарч ажиллах талаар тусгах юм.

Оролцоонд тулгуурласан байгаль орчны хяналт шинжилгээ (ОТБОХШ)-ний хөтөлбөрийг Мөнх ногоон галба ТББ хэрэгжүүлж байгаа ба хяналт шинжилгээ хийхэд талуудын оролцоо нэмэгдсээр байна. Усны мониторингийн хөтөлбөрт далан найман малчин оролцож байгаа ба 20 малчин зэрлэг амьтдын мониторинг хөтөлбөр (2019 оны 6-р сараас эхлэх) хэрэгжүүлэх сургалтад хамрагдаж, бусад 60 гаруй малчин ОТБОХШ-ний бусад үйл ажиллагаанд оролцсон байна. Тус ТББ-ын үйл ажиллагааны хүрээнд оролцогч талуудын байгаль орчны талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх; 2018/19 онд 9 газарт 41 хоногийн арга хэмжээ зохион байгуулж, орон нутгийн 1,280 малчинд хүрч ажилласан байна. ОТ-н байгаль орчин, нийгэмтэй холбоотой тоо мэдээг танилцуулж, мэдээлэл өгсөн талаарх мэдээллийг дээр байгаа Устай холбоотой хэсгээс үзнэ үү. ТББ-ын гурван жилийн стратегид ажилтнуудын чадавхийг бэхжүүлэх, мэргэжлийн сургалтад хамруулах, цаашид малчдын идэвхи оролцоог нэмэгдүүлэх, тогтвортой үйл ажиллагаа явуулах, ТББ-ын ОТБОХШ-ний тоо мэдээ бүхий олон нийтэд нээлттэй мэдээллийн сан үүсгэх зэрэг ажлууд багтсан.

Бүс, орон нутгийн хөгжил

2019 оны 2-р сард ХДС-ийн ТУЗ дэд бүтэц, боловсрол, хөдөө аж ахуйн хөтөлбөрүүдийг хамруулсан хэд хэдэн төслийг хэрэгжүүлэхээр баталсан ба үүнд гурван жилийн хугацаатай хэрэгжих Хөдөө аж ахуй, малын эрүүл мэндийн хөгжлийн хөтөлбөр (2019-2022) багтсан. ХДС-ийн санхүүжилт, дэмжлэгтэйгээр ихээхэн ажлууд хийгдсэний хүрээнд Түргэн тусламж, мэс заслын дэмжих үйлчилгээний ажилтнуудын чадавхийг сайжруулах хөтөлбөр, Ханбогдын цэцэрлэг, сургуулийн цогцолборын ажил багтана. ХДС-ийн хэрэгжүүлсэн ажлууд нутгийн ард иргэд, гол оролцогч талууд, орон нутгийн удирдлагуудаас эерэг үнэлгээ авсан.

Мөн төсөл хөтөлбөрт санхүүжил олгох шинэ механизм нэвтрүүлж, арван сумтай “Санхүүжилтийн квотын гэрээ” байгуулан, ХДС-ийн санхүүжилт олгох зарчим болоод ёсзүйн дүрмийн дагуу тэгш боломжоор хангаж байна. Нийгмийн эмзэг бүлгийн иргэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өндөр настан, тусгай хэрэгцээт иргэд, малчдын амьжиргааг дэмжих, биеийн эрүүл мэнд болон эдийн засгийн таатай нөхцөл боломж бүрдүүлэх зорилгоор 2018 онд 370,000 ам.доллар, 2019 онд 400,000 ам.доллартай тэнцэх хэмжээний санхүүжилтийн квот олгосон.

Аудит хийж байх үед Хүн амын шилжин ирэх хөдөлгөөнийг удирдах төлөвлөгөөг 2019 оны 7-р сард дуусгах төлөвлөгөөтэйгээр хянан шинэчилж байсан. Орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ажлын хэсэг хөдөлмөр эрхлэх боломж нөхцөл бүрдүүлэхэд чиглэсэн ажлуудыг авч хэрэгжүүлсээр байгаа ба одоо 1,632 ажилтан Ханбогдод амьдарч байгаа ба энэ нь 2017 оны тоо мэдээтэй харьцуулахад 28% өссөн үзүүлэлт юм. Орон нутгаас худалдан авалт хийх ажлын хэсэг мөн идэвхитэй ажиллаж, сар тутам ОТ-д нийлүүлэлт хийх мэдээллийн уулзалт (түнш 10 сумдад), жижиг, дунд бизнес эрхлэгчдийг хөгжүүлэх сургалт зохион байгуулдаг ба 2019 оны 4-р сард нээлтээ хийсэн Бизнесийн инновацийн өсөлтийн төвийг байгуулсан. Хамтын ажиллагааны хороо Ханбогд болон Өмнөговийн хөгжлийн стратеги боловсруулахад талуудын хамтын ажиллагаанд гол үүрэг гүйцэтгэсэн ба 2018 онд НҮБ-ын Хүн амын сан, Үндэсний статистикийн хорооны хийсэн Өмнөговь аймгийн нийгэм эдийн засгийн суурь судалгаа зэрэг хүн амын шилжин ирэх хөдөлгөөнтэй холбоотойгоор бий болж буй үр дагаварын талаар түнш байгууллагуудын хэрэгжүүлсэн бусад төслүүдэд ихээхэн үүрэг гүйцэтгэсэн.

Ажилтнуудын эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа

Гүний уурхайн төсөлтэй холбоотойгоор уурхайд ажиллах ОТ үндсэн болон гэрээт ажилтнуудын тоо оргил үедээ хүрч байгаатай уялдуудан эрүүл мэндийн хэлтсийн нөөц, хүчин чадлыг мөн нэмэгдүүлсэн. Гүний уурхайн төслийг ОТ Үйл ажиллагааны хэлтэстэй нэгтгэх ажлын хүрээнд Хөдөлмөрийн эрүүл мэнд, эрүүл ахуйн хэлтэс эрүүл мэндийн хяналт, мэргэжлээс шалтгаалах өвчний мэдээ, тайлангийн баримт бичиг, журмуудаа шинэчилж, эрүүл мэндийн хугацаат үзлэгийн хуваарь, зохицуулалтыг хариуцсан Хөдөлмөрийн эрүүл мэндийн багийг УБ-т байгуулсан. 2019 оны 2-р сард Үйл ажиллагааны Эрүүл ахуйн баг эрүүл ахуйн хяналтын хөтөлбөр дээр Гүний уурхайтай хамтран ажиллах боломж, Эрүүл мэндийн баг нэмэлт сургалт, боловсрол олгох, технологи нэвтрүүлэх зэргээр алжаал ядаргааны менежмент, сэтгэлзүйн эрүүл мэнд, сайн сайхан байдлын хөтөлбөрүүдэд ач холбогдол өгч ажилласаар байна.

2019 оны 4-р сард эрүүл мэнд, аюулгүй байдлын 14 “ноцтой” осол зөрчил илэрсэн бөгөөд үүнээс найм нь бэртэл гэмтэл авсан тохиолдол байсан бол хоёр нь амь нас эрсдэж болзошгүй тохиолдол байсан. Эрүүл мэнд аюулгүй ажиллагаатай холбоотой эдгээр ноцтой осол зөрчлийн ес нь гүний уурхайд гарсан бол тав нь одоо үйл ажиллагаа нь явагдаж байгаа ил уурхайн хэсэгт гарсан. 2019 оны 4-р сар хүртэлх хугацаанд ОТ 12 сарын хугацаанд Бүх осол гэмтлийн давтамжийн үзүүлэлт (БГДҮ)-ийг 0.13-т барьсан бөгөөд энэ нь 0.21 гэсэн зорилтын түвшнээс доогуур үзүүлэлт юм. Гүний уурхайн үйл ажиллагаанд гарсан осол зөрчлийн тоо арай олон байсан ч БГДҮ 0.20 байсан нь Гүний уурхайн зорилтот түвшин болох 0.26-с доогуур байгаа юм. Гүний уурхайн бүтээн байгуулалтад 40 сая гаруй хүн цаг ажилласан ба бүтээн байгуулалтын ажил ойролцоогоор 54%-тай байна. ОТ Үйл ажиллагааны хэсгийн БГДҮ 0.04 байсан нь зорилтот түвшин болох 0.15-с доогуур байгаа юм. Аюулгүй ажиллагааны осол зөрчил, суурь шалтгаан, залруулах арга хэмжээний талаарх дэлгэрэнгүй мэдээллийг БОНХЗ-ийн төлөөлөл ЭМАА-ны ажилтнуудтай биечлэн уулзах боломж бүрдэхээр буюу БОНХЗ-ийн дараагийн аудитын тайланд тусгах болно.

Орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй ажилла гаа

ОНИЭМАААБМТ-г хоёр жил тутамд хийдэг хянан хэлэлцдэг бөгөөд 2018 онд хянан шинэчилж, түнш сумд болон аймгийн хэмжээнд иргэдийн эрүүл мэндийн бодит байдлыг харгалзан үзэж хөтөлбөр хэрэгжүүлэх зорилтот газруудыг сонгож оруулсан. ХДС-гийн дэмжлэгтэй хэрэгжиж буй Иргэдийн эрүүл мэндийг сайжруулах хөтөлбөрүүдэд: залуус, өсвөр үеийнхэнд ээлтэй эмнэлэг үйл ажиллагаагаа явуулж, 289 хүүхэд залууст үйлчилж, үе тэнгийн сургагч багш бэлтгэсэн; Манлай суманд Эрүүл наслахуй хөтөлбөр хэрэгжиж байна; Ханбогд дахь сум дундын эмнэлэг явуулын тоног төхөөрөмж ашиглан нийт 348 малчинд хүрч үйлчлэн эрүүл мэндийн байдлыг нь үнэлсэн байна. Говийн Оюу ХДС, Unisef, ДЭМБ, НҮБ-ын Хүн амын сан, Австралийн Засгийн газар хооронд байгуулсан дөрвөн жилийн түншлэлийн гэрээний хүрээнд эх, хүүхдийн эрүүл мэндэд чиглэсэн хөтөлбөр хэрэгжиж байна.

ОТ-Ханбогдын авто зам ашиглалтад орохтой зэрэгцээд орон нутгийн иргэдэд автозамын аюулгүй байдлыг хангах сургалт зохион байгуулж, замын тэмдэг тэмдэглэгээ байрлуулах зорилгоор Автозамын аюулгүй байдлыг хөтөлбөрийг шинээр эхлүүлж, Ханбогдын сургууль дээр Эрсдэлийн үзүүлэх сургалтын төв ажиллуулж эхэлсэн. Энэхүү хөтөлбөрийг ОТ болон НҮБ-ын Хүн амын сангийн санхүүжилтээр аймаг, сумын ЗДТГ, Цагдаагийн хэлтэстэй хамтран 2019 онд хэрэгжүүлэх юм.

Соёлын өвийн менежментийн тогтолцоо

Соёлын өвийн менежментийн төлөвлөгөө хэрэгжиж байгаа бөгөөд соёлын өвтэй холбоотой ямар нэг зөрчил бүртгэгдээгүй ба аудитын хугацаанд орон нутгийн иргэдэд мэдээлэл өгөх уулзалт, соёлын өвтэй холбоотой чиглүүлэх сургалт нийт 625 удаа хийсэн байна. Аудитын хугацаанд газар хөндөх нийт 44 зөвшөөрөл олгосон байна.

2018 онд соёлын өвийн чиглэлээр хэрэгжүүлсэн гол ажлуудаас дурдвал 160 хүнд соёлын өвийг сахин хамгаалагчийн сургалт хийж, Даланзадгад сумын музейг ашиглалтад оруулсан ба Ханбогдын ахмадын холбоотой хамтран ажиллаж байна. 2018 онд тус холбооны ахмадууд нийт 2,606 сурагчид сургалт хийж, орон нутгийн иргэд, ОТ ажилтнууд, зочин гийчид нийлсэн 2,000 иргэнийг ОТ Уламжлалын өргөөнд хүлээн авсан. 2019 оны 3-р сард Уламжлалын өргөөнд зочид хүлээж авах ажлыг зохион байгуулах чиглэлээр Ахмадын холбоотой хамтран ажиллах гурван жилийн гэрээ байгуулсан нь Ханбогд сумын нийгмийн идэвхитэй энэхүү бүлэгтэй харилцаа, хамтын ажиллагаагаа бэхжүүлэхийн давуу талыг ойлгож, хүлээн зөвшөөрсний илрэл юм.

1 УДИРТГАЛ

Оюу толгой төсөл нь (цаашид “Төсөл” буюу “ОТ Төсөл” гэх) Монгол улсын Өмнийн говийн бүс нутаг Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрт, нийслэл Улаанбаатар хотоос өмнө зүгт ойролцоогоор 600 км, Монгол-Хятадын хилээс хойд зүгт 80 км-т оршдог. Тус ашигт малтмалын ордыг 2001 онд нээж илрүүлсэн бөгөөд зэс, алт, мөнгө, бага хэмжээний молибден агуулсан хэд хэдэн бүлэг ордноос бүрдэнэ. Тус төсөл нь Ил уурхай, Гүний уурхайг хамрах бөгөөд Баяжуулах үйлдвэр өдөрт 100,000 тонн баяжмал боловсруулан гаргаж, жилд 500,000 гаруй тонн баяжмал үйлдвэрлэнэ гэж тооцоолж байна. 2013 оны 7-р сараас хэрэглэгч нартаа бүтээгдэхүүнээ тээвэрлэн хүргэж эхэлсэн.

2013 оны 9-р сард “Оюу толгой” ХХК (цаашид “Төслийн компани” буюу ОТ гэнэ) өөрийн хэрэгжүүлж буй Оюу толгой төслийн (Монгол улс засгийн газар, Рио Тинто групп (цаашид РТ гэнэ), Туркуойз Хилл Ресурс компани хоорондын стратегийн түншлэл) Байгаль орчин, нийгмийн хөндлөнгийн зөвлөхөөр (БОНХЗ) Итали улсын Генуя хотод байрладаг Д'Апполониа ХК (2017 оны 6-р сарын 5-с эхлэн АрАйЭнЭй Консалтинг болсон)-ийг ажиллуулахаар гэрээ байгуулсан. 2012 оноос эхлэн РТ групп нь төслийн бүх хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчдыг төлөөлөн төслийн менежментийг хариуцахаар томилогдсон.

АрАйЭнЭй Консалтинг компани нь БОНХЗ-ийн хувьд давуу эрхтэй зээлдүүлэгчдэд ¹ зориулан 2013 оны 9-р сарын 1-нд эхэлсэн ОТ уурхайн ашиглалтын (Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчин) ЭМААБО, нийгмийн чиглэлд гол анхаарлаа хандуулан хөндлөнгийн үнэлгээ хийж гүйцэтгэх үүрэгтэй. БОНХЗ нь уг үүргийнхээ хүрээнд ОТ төсөл Үйл ажиллагааны менежментийн төлөвлөгөөндөө тусгасан байгаль орчин, нийгмийн өмнө хүлээсэн үүрэг хариуцлагаа биелүүлж байгаа эсэхийг давуу эрхтэй зээлдүүлэгчдэд тайлагнах бөгөөд уг төлөвлөгөө нь БОННУ болон бусад холбогдох бичиг баримтад тодорхойлсон нөлөөллийг бууруулах стратегийг ОТ компани хэрхэн хэрэгжүүлэхийг заасан баримт бичиг юм. Эдгээр нь ирээдүйд тодорхой цаг хугацаатай гүйцэтгэх үйл ажиллагааны жагсаалт, мөн БОНХЗ төслийн Байгаль орчин, нийгэм, эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны (БОНЭМАА) гүйцэтгэлд хяналт шинжилгээ хийхдээ ашигласан лавлагаа баримт бичиг болсон Ашиглалтын БОНМТ-үүдийг агуулсан төслийн Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ (БОННУ), Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны төлөвлөгөө (БОНУАТ) болно.

Энэхүү тайланд 2018 онд баримт бичигт тулгуурлан хийсэн үнэлгээ болон Оюу толгойн Байгаль орчин, нийгмийн жилийн тайлан, БОНХЗ-ийн хүсэлт гаргасан дагуу ту компанийн гаргаж өгсөн мэдээлэл, мөн ОТ уурхайн ажилтнуудтай хийсэн теле хуралд үндэслэн үнэлгээ хийх үеийн Төслийн нөхцөл байдалд хийсэн дүгнэлтийг тусгалаа. Энэ тайлангийн үйл ажиллагааны менежментийн төлөвлөгөө, төслийн түүхтэй холбоотой хэсэг дэх ерөнхий мэдээлэл нь БОНХЗ-ийн өмнөх тайлангуудаас иш татсан болно. БОНХЗ-ийн өмнөх тайланд Төслийн анхаарах ёстой гол чиглэлүүдийн нөхцөл байдлын талаар шинэчилсэн мэдээлэл өгснөөс гадна БОНХЗ-ийн өмнөх тайлангуудад тэмдэглэсэн зөрчлүүдийн талаар хэрэгжүүлж буй ажлын явц ямар байгаа талаар тусгасан. Энэ тайланд дурдагдаагүй сэдвүүдээр зөвлөх 2019 оны 4-р улиралд уурхайд ажиллахдаа авч үзэх болно.

Дараах тодорхой үйл ажиллагааг хэрэгжүүлсэн:

- ОТ-н Байгаль орчин, нийгмийн 2018 оны тайлантай танилцах;
- ЭМААБО болно нийгмийн нэмэлт баримт бичгүүд болон ОТ-с гаргаж өгсөн төсөлтэй холбоотой бусад баримт бичигтэй танилцах;
- 2019 оны 5-р сарын 27-с 6-р сарын 3-ны хооронд ЭМААБО болон нийгмийн дүрэм журмын хэрэгжилт хариуцсан төслийн багуудтай теле хурал хийх;
- Үйл ажиллагааны үе шатны БОНМТ-үүд, БОНАХТ-нд тусгасан үүргүүдийн хэрэгжилтийг үнэлэх;
- Үйл ажиллагааны менежментийн төлөвлөгөө болон БОНМХ-т тусгасан үүрэг хариуцлагаас гажсан буюу аль эсвэл зөрүүтэй, дутагдалтай зүйл байгаа эсэхийг тодорхойлж, Салбарын олон улсын тэргүүн туршлагад (СОУТТ) үндэслэн ЭМААБО-г сайжруулах чиглэлээр зөвлөмж өгөх;

1 Давуу эрхтэй зээлдүүлэгчдийн группэд: Олон Улсын Санхүүгийн Корпораци (ОУСК), Европын сэргээн босголт, хөгжлийн банк (ЕСБХБ), Канадын экспортын хөгжлийн байгууллага (КЭХБ), АНУ-ын экспорт импортын банк (АНУ ЭИБ), Экспортын санхүү, даатгалын корпораци (ЭСДК), Олон талын баталгаа гаргагч агентлаг (ОТБА), Стандарт чартеред банк (СЧБ), БиЭнПи Парибас нар багтана.

- БОНХЗ-ийн 2018 оны 9-р сард уурхайд ажилласан Аудитын тайланд² тодорхойлсон дүгнэлт, ажиглалтын мөрөөр гүйцэтгэлийг хянаж, арилсан зөрчлийг хаах.

Энэхүү тайланд дурдсан мэдээлэл, ажиглалт, үзэл бодол нь АрАйЭнЭй Консалтинг компанийнх бөгөөд тэдгээр нь Төсөл болон/эсвэл давуу эрхтэй Зээлдүүлэгчдээс хараат бус, бие даасан болно. Тайланд дурдагдаагүй сэдвүүдийн тухайд ямар нэг эрсдэлтэй зүйл төслийн хүрээнд илрээгүй болно.

² АрАйЭнЭй Консалтинг, “Байгаль орчин, нийгмийн хууль, дүрмийн хэрэгжилтийн хөндлөнгийн хяналтын тайлан - 2018 оны 9-р сард уурхайд ажилласан тайлан”, баримт бичиг. Дугаар. P0010806-2-H1 Хувилбар. 0, 2018 оны 12-р сар.

2 ТӨСЛИЙН ТОЙМ

2.1 БАРИЛГА, АШИГЛАЛТЫН ЯВЦ

Уг төсөл нь зэс, алт, мөнгө, молибдены хэд хэдэн ордоос бүрдэх ба урьд нь БОНХЗ-ийн тайланд дурдаж байсанчлан далд болон ил уурхайн арга техникийг хослуулан олборлодог.

Ил уурхайгаас 2012 оны 2-р улиралд хоногт 24 цаг тасралтгүй энгийн хүнд даацын машин болон экскаватор ашиглан олборлож эхэлсэн. Гүний уурхайг блокчлон олборлох аргаар олборлохоор төлөвлөж байгаа ба хүдрийн дор тулгуур үлдээн малтлага хийснээр хүдэр нь хүндийн хүчний үйлчлэлээр малтлага хийсэн хоосон орон зай руу өөрөө нурж орох замаар олборлоно. Гүний уурхайн олборлох арга нь үр ашигтай, өртөг зардал багатайгаас гадна хаягдал шороо чулуу бага гардаг, том хэмжээний хүдрийн биет олборлох боломжтой юм.

Хүдрийг баяжмалд хувиргах процессын загварыг энгийн бутлах, хөвүүлэн баяжуулах технологи болон батлагдаж туршигдсан тоног төхөөрөмж ашиглахад үндэслэн гаргасан. Тус процесст том бутлагдсан хүдрийг овоолж, анхдагч бутлуураар бутлах үйл ажиллагаа орно. Анхдагч бутлуураар буталсан хүдрийг 2.7 км урт газрын гадаргуу дээрх туузан дамжуулагчаар баяжуулах үйлдвэрийн ойролцоо байрлах овоолго руу хүргэж, тэндээсээ хүдрийг жижигсгэн бутлах том диаметртэй цувраа тээрэм рүү шилжүүлнэ. Хөвүүлэн баяжуулах систем нь зэс агуулсан материалыг дараагийн үе шатанд боловсруулахаар шүүн авах ба флотацын том бассейн дотор шаардлага хангахгүй эрдсийг үнэ цэнэтэй хүдрээс ялгаж авдаг. Энэ зуур лагийг (хаягдал) хоёр өтгөрүүлэгчид 60% хатуу болгож өтгөрүүлээд, Хаягдал хадгалах байгууламжид (ХХБ) шахаж зайлуулдаг. Хаягдал өтгөрүүлэгч болон ХХБ-аас гарсан усыг баяжмал үйлдвэрлэхэд дахин ашиглана. Үүний дараа зэс, алт агуулсан эцсийн бүтээгдэхүүн болох баяжмалыг өтгөрүүлж шүүгээд битүүмжилсэн уутанд хийж савлан, ачааны машинаар Хятад улс руу Гашуун Сухайт/Ганц модны боомтоор дамжуулан тээвэрлэнэ. 2018 онд Оюу толгой тээвэрийн бусад боломжит хувилбарыг туршиж, Төслөөс зүүн хойш 450 км-ийн зайд орших Чойрын төмөр замын өртөө хүртэл цуваагаар тээвэрлэх, мөн Улаанбатараар дамжин тээвэрлэх зэрэг туршилтуудыг хийсэн.

2013 онд түр зогсолт хийсний дараа Гүний уурхайн үйл ажиллагаа 2016 онд Гүний уурхайн төслийг үргэлжлүүлэх хөтөлбөрийн дагуу дахин эхэлж, 2017, 2018 онуудад шаардлагатай нөөц, хүн хүчээ бүрдүүлж эхэлсэн. 2019 оны 1-р улирлын байдлаар гүний уурхайн хүний нөөц оргилдоо хүрч уурхайн талбарт байрлаж ажиллаж байгаа ажилтнуудын тоо 8,755-д хүрсэн. Ил болон гүний уурхайн дэд бүтцийг барьж байгуулах ажил дуусах үеэр энэ тоо буурах төлөвтэй байна. Томоохон хэмжээний дэд бүтцийн барилгын ажлууд дууссан бөгөөд энэ тайланг бэлтгэх үед нийт барилгын ажлын гүйцэтгэл 54%-тай байв. ДТС-ын өргөтгөлийн ажил дуусч, 2019 оны сүүлчээр хүйтний улирал дундаа орж жигдрэхээр ашиглалтад оруулах гэж байна. Гүний уурхайн бүтээн байгуулалт, хонгилын байгуулалтыг дуусгаснаар уурхай 2020 эсвэл 2021 оноос эхлэн гүний уурхайн хүдрийн биетээс олборлолт хийж, ил уурхай хүдрийн биетээс илүү өндөр агуулгатай хүдэр олборлоно гэж төлөвлөж байгаа ба үүний үр дүнд зэсийн үйлдвэрлэл ихээхэн нэмэгдэнэ.

Уурхайн үйл ажиллагааны нэмэлт туслах байгууламжид орон нутгийн онгоцны буудал, Хятад улсын хойд хэсэгт орших Өвөр Монголын цахилгаан эрчим хүчний сүлжээнээс өндөр хүчдэлийн шугамаар дамжуулан авах 220 киловаттын (кВ) цахилгаан дамжуулах шугам, нүүрсээр галладаг дулааны төв станц (ДТС), ус хангамж, бохир ус цэвэрлэх байгууламж, засварын цех, агуулах, захиргааны байр, хог хаягдлын байгууламж, түлш хадгалах депо, захиргааны байр, орон сууц, авто зам, тээврийн байгууламж зэрэг орно.

2018 оны 2-р сард Монгол улсын Засгийн газар Эрчим хүчний салбарт хамтран ажиллах гэрээг цуцлах саналтай байгаагаар ОТ-д мэдэгдсэн. Ийнхүү уг гэрээг цуцалснаар ОТ дөрвөн жилд багтааж дот оодоос эрчим хүч авах эх үүсвэр байгуулах шаардлагатай болсон. Барихаар төлөвлөж буй нүүрсээр галладаг Цахилгаан станц болон баяжуулах үйлдвэрийг хоногт 100 мянган тонн-с дээш баяжмал үйлдвэрлэх хүчин чадалтай болгож нэмэгдүүлэх ажлуудад БОНУАТ-нд тусгасны дагуу БОНХЗ-ийн үнэлгээ хийлгэх шаардлагатай.

2.2 ТАЙЛАНГИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Энэхүү тайланг дараах байдлаар бүлэг болгон зохион байгуулав:

- 3-р бүлэг – Зөрчлийн хүснэгт;
- 4-р бүлэг – Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчин, нийгмийн хариуцлагын менежментийн тогтолцоо;
- 5-р бүлэг – Байгаль орчин;
- 6-р бүлэг - Нийгэм;

- 7-р бүлэг - Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа;
- 8-р бүлэг - Соёлын өв.

БОНХЗ-ийн хяналт шалгалтаар илэрсэн үндсэн үр дүнг ажиглалт, тайлбар, зөвлөмж хэлбэрээр энэхүү тайланд тусгасан болно. Хоёр төрлийн үр дүнг багтаасан:

- Үйл ажиллагааны менежментийн төлөвлөгөө ба/эсвэл СОУТТ-д тодорхойлсон Төслийн үүрэг амлалттай холбоотойгоор Илэрсэн зөрчлийн хураангуйлсан хүснэгт (3-р хэсэг) -д харуулсан зөрчлүүд;
- БОНХЗ-ийн багийн гишүүдийн хамтын мэдлэг, туршлагад үндэслэн тодорхойлж, хэсэг болгоны (4-8) төгсгөлд тусгасан, цаашид авах шаардлагатай арга хэмжээ, нээлттэй асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар зөвлөсөн санал зөвлөмжүүд.

БОНХЗ-ийн өгсөн зөвлөмжүүд нь заавал биелүүлэх шаардлага биш тултэдгээрийг нэн тэргүүнд хэрэгжүүлэх шаардлага тавигдахгүй. Гэсэн хэдий ч БОНХЗ-ийн өгч байгаа бүх зөвлөмжийг ашигтай, ач холбогдолтой талаас нь харж, хэрэв техник эдийн засгийн талаасаа тохиромжтой бол менежментийн цаашдын үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллахыг Төслөөс хүсэж байна.

3 ЗӨРЧЛИЙН ХҮСНЭГТ

Энэ бүлэгт баримт бичигт суурилсан үнэлгээний энэхүү тайланд тодорхойлсон зөрчлүүдийг хүснэгтээр хураангуйлан үзүүлсэн болно (Хүснэгт 3.1). Тухайн зөрчил дутагдал нь ЯАМТ, БОНМХ, ОТ төслийн хяналт шинжилгээний баримт бичиг, журамд тодорхойлсон ОТ төслийн байгаль орчин, нийгмийн өмнө хүлээсэн хариуцлагын хувьд хэр ноцтой болохыг тодорхойлох, ОТ төслийн ашиглалтын үйл ажиллагаа нь зээлдүүлэгч байгууллагуудын Байгаль Орчин, Нийгмийн холбогдох шалгуурт хэрхэн нийцэж буйг тодорхойлохын тулд хүснэгтийг өнгөөр кодлон ангилсан болно. Өнгөөр кодолсон ангиллыг РТ-ийн ЭМААБООН Менежментийн Системийн ангиллын дагуух ОТ төслийн БОНМТ-нд³ тодорхойлсон зөрчил дутагдлын ижил түвшинд үндэслэн оноосон юм.

Дараах байдлаар тайлбарлав:

- **IV ангилал** - Төслийн стандарт эсвэл Менежментийн төлөвлөгөөг ноцтой зөрчсөн бөгөөд экологийн эсвэл нийгмийн чухал нөөц, эмзэг хүлээн авагчдад нөхөж баршгүй нөлөөлөл эсвэл ихээхэн хор хохирол учруулсан буюу учруулж болзошгүй эсвэл эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны ноцтой осол эндэгдэл учруулж болзошгүй маш ноцтой зөрчил;
- **III ангилал** - Төслийн стандарт эсвэл Менежментийн төлөвлөгөөг ноцтой зөрчсөн бөгөөд экологийн эсвэл нийгмийн чухал нөөц, эмзэг хүлээн авагчдад нөхөж баршгүй нөлөөлөл эсвэл ихээхэн хор хохирол учруулах эсвэл эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны ноцтой осол эндэгдэл учруулах нь тодорхой илрээгүй хэдий ч тийм үр нөлөө үзүүлж болзошгүй бодитой зөрчил;
- **II ангилал** - Төслийн стандарт эсвэл Менежментийн төлөвлөгөөг зөрчсөн хэдий ч экологийн эсвэл нийгмийн чухал нөөц, эмзэг хүлээн авагчдад нөхөж баршгүй нөлөөлөл эсвэл ихээхэн хор хохирол учруулах хэмжээний биш, эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны ноцтой осол эндэгдэл учруулахааргүй бодитой зөрчил;
- **I ангилал** - Төслийн стандарт эсвэл Менежментийн төлөвлөгөөг бүрэн дагаж мөрдөөгүй бөгөөд байгаль орчин, орон нутгийн ард иргэд эсвэл ажилчдын эрүүл мэнд, аюулгүй ажиллагаанд нөлөөл үзүүлэх магадлал байхгүй.

Хэрэгжүүлэх арга хэмжээг үүрэг даалгаврын дугаараар ангилсан ба (үүрэг даалгаварын Х.Ү дугаар) энд Х нь үүрэг даалгаврын дугаар, Ү нь хэрэгжүүлэх холбогдох арга хэмжээний дугаарыг илтгэж байна. Заавар зөвлөмжийг тодорхойлсон текстийг нэг аудитаас нөгөө аудитын хооронд тухайн үеийн нөхцөл байдлыг илүү тодорхой тусгаж өгөхийн тулд хянаж засвар оруулах шаардлагатай гэдгийг цохон тэмдэглэх хэрэгтэй. Гэхдээ анхны дугаарууд нэг ижил үндсэн асуудалд хамаарч байгаа учраас тухайн асуудлыг шийдвэрлэж хаах хүртэл хэвээр үлдээлээ.

Хүснэгтэд тодорхойлсон төсөлтэй холбоотой зөрчил тус бүрт ОТ ямар нэгэн арга хэмжээ авах шаардлагатай бөгөөд БОНХЗ дараагийн аудитаараа биелэлтийг нь шалгана. Хүснэгтэд мөн илрүүлсэн зүйлсийн тодорхойлолт, оноосон зөрчлийн түвшин, Төслийн хүлээсэн үүрэг хариуцлагад хамаарч буй холбогдох баримт бичиг, мөн БОНХЗ-ийн хамтын мэдлэг туршлага дээр үндэслэн өгч буй засаж залруулах буюу сайжруулах талаар өгсөн зөвлөмжүүд багтаж байна. БОНХЗ-ийн үзэж байгаагаар зөрчлийг хангалттай хэмжээнд шийдвэрлээгүй тохиолдолд, нөхцөл байдлаас шалтгаалаад бодит үр дагавраас үл хамааран зөрчлийн ангилал нэмэгдэж болзошгүй гэдгийг санах хэрэгтэй ба ямар нэгэн засаж залруулах арга хэмжээ авахаас зайлсхийсэн тохиолдолд үндэслэлтэй тайлбар шаардлагатай юм.

Ерөнхийдөө аудитын үр дүнг дараах байдлаар тодорхойлов:

- IV ангилалд хамаарах зөрчил илрээгүй non-conformances have been identified;
- III ангилалд хамаарах зөрчил илрээгүй;
- II ангилалд хамаарах нэг зөрчил илэрсэн; мөн
- I ангилалд хамаарах гурван зөрчил илэрсэн.

³ Байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө (БОНМТ) – баримт бичгийн дугаар ОТ-10-PLN-0003 2013.01.09.

Хүснэгт 3-2 Зөрчлийн хүснэгт

| Даалгавар/асуудлын дугаар | Уурхайн аудит | Хаасан огноо | Тайлбар | Зөрчил | Лавлах баримт бичиг | Төлөв | Тайлбар/холбогдох тайлан |
|---|---------------|--------------|---|--------|--|----------|--|
| Байгаль орчин – Ус, хаягдал усны менежмент | | | | | | | |
| M13.1 | 5-р сарын 19 | | Манлай БУЦБ-ийн цэвэршүүлсэн усны Химийн хүчилтөрөгчийн хэрэгцээ, Биологийн хүчилтөрөгчийн хэрэгцээний үзүүлэлтүүд, аммиак, фосфорын хэмжээ нь Төслийн стандартаас хэтэрсэн байсан. | I | Усны менежментийн төлөвлөгөө, Хавсралт А | Нээлтэй | 5.1.2.10 хэсгийг үзнэ үү. ТМанлай 1 болон Манлай 2 БУЦБ-ийн цэвэршүүлсэн усан дахь аммиакын хэмжээ сүүлийн үед Төслийн стандартаас хэтэрсэн дүнтэй харагдаж байна (2019 оны 1-р сард 29 мг/л, 2-р сард 20 мг/л). Мөн Манлай 2 БУЦБ-ид Химийн хүчилтөрөгчийн хэрэгцээ, Биологийн хүчилтөрөгчийн хэрэгцээний үзүүлэлтүүд нь Төслийн стандартаас хэтэрсэн байсан. Төслийн зүгээс эдгээр үзүүлэлтүүд хэтрэх болсон шалтгаан нь доод ерөөнөөс орж буй бохирын оролттой холбоотой байж магадгүй гэж таамаглаж байгаа ба хэвийн үйл ажиллагааг тасалдуулахгүйгээр Химийн хүчилтөрөгчийн хэрэгцээний үзүүлэлт өндөртэй усны оролтын хурдыг сааруулах журамд өөрчлөлт оруулсан. БОНХЗ энэ асуудалд хараа хяналт тавьж, шинжилгээний дүн нь Төслийн стандартад нийцэж, урт хугацаанд тогтвортой байгаа эсэхийг магадлана. |
| Байгаль орчин – Агаарын чанар | | | | | | | |
| M12.1 | 9-р сарын 18 | 5-р сарын 19 | Орчны агаарын чанарын мониторингийн дүнгээс үзэхэд SO ₂ жилийн зөвшөөрөгдөх дээд түвшнээс хэтэрсэн үзүүлэлттэй байна. | I | Агаарын чанарын хяналт шинжилгээний төлөвлөгөө | Хаагдсан | 5.5.2.1 хэсгийг үзнэ үү. OT SO ₂ хэмжээ хэтэрсэн шалтгааныг судалсан боловч тоо мэдээний тархалт нь тогтмол бус байгаагаас суурь шалтгааныг тогтоох тодорхой дүгнэлтэд хүрч чадахгүй байна. # 4 станц дээр байрлуулсан мониторингийн төхөөрөмжийн үр дүнд автомашины утаа нөлөөлсөн байж болзошгүй гэж таамаглаж байна. Барилгын ажил дууссанаас хойш буюу 2018 оноос хойш 24-цагийн өдрийн дундаж үзүүлэлт хэтэрч байсан удаагүй. Энэхүү сүүлийн үеийн тоо баримтад тулгуурлан SO ₂ концентрацитай холбоотой энэ зөрчлийг хааж байна; гэхдээ БОНХЗ нь орчны агаарын чанарын тоо мэдээнд хяналт тавихаа зогсоохгүй ба 24-цагийн орчны агаарын чанарын үзүүлэлт ямар нэг байдлаар дахин хэтэрч байгаа эхэсийг хянах болно. |

ОЮУ ТОЛГОЙ УУРХАЙН ТӨСӨЛ

| Даалгавар/асуудлын дугаар | Уурхайн аудит | Хаасан огноо | Тайлбар | Зөрчил | Лавлах баримт бичиг | Төлөв | Тайлбар/холбогдох тайлан |
|---------------------------|--|--------------|--|--------|--|----------|---|
| M1.11 | 13 оны 10-р сар 14 оны 4-р сар 14-оны 8-р сар-баримт бичгийн 14 оны 11-р сар 15 оны 4-р сар-баримт бичгийн 15 оны 9-р сар 16 оны 4-р сар-баримт бичгийн 16 оны 8-р сар 17 оны 5-р сар 18 оны 9-р сар 19 оны 5-р сар-баримт бичгийн | | Том ширхэгтэй хүдрийн овоолгоос их хэмжээний тоос (тоосонцор) босдог. Тоосонцорын хяналт шинжилгээний дүн Төслийн стандартаас хэтэрсэнийг харуулж байгаа тул зөрчилд тооцогдоно. | I | Агаарт ялгарах хийн хаягдлын менежментийн төлөвлөгөө | Нээлттэй | <p>5.5.2.2 хэсгийг үзэх. Том ширхэгтэй хүдрийн овоолгын (ТШХО) байгууламж тоосжилт ихтэй байсаар ирсэн. Үйл ажиллагаанд хэд хэдэн удаа өөрчлөлт оруулж, хэд хэдэн төрлийн арга хэмжээ хэрэгжүүлснээр Хүдрийн овоолгын байгууламж орчмын агаарт тогтсон нийт тоосны нягтрал (TSP) нүдээр харахад багассан харагдаж байна. Саяханаас ОТ ТШХО-ын гурван талд “тоосны хөшиг” суурилуулсан.</p> <p>ТШХО-ын тоосжилтын нөхцөл зарим талаар дээрдсэн үзүүлэлт ялангуяа DMP-COS02 станц дээр ажиглагдсан. Нарийн ширхэгт тоосонцор хэмжсэн үзүүлэлт Төслийн стандартаас хэтэрсэн хэвээр байна. Гэхдээ тоосны хөшиг суурилуулснаас хойш цуглуулсан мониторингийн дээж нь зөвхөн гурван удаагийн мэдээ тул цаашид цагаар мэдээ авч хандлагыг тодорхойлох шаардлагатай.</p> <p>Асуудлын гол нь баяжуулах үйлдвэр зэрэг ТШХО-ын ойр орчимд ажилладаг ажилтнуудын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйтай (ХАБЭА) холбоотой. Ажилтнууд одоогоор амьсгалын аппарат зүүж байгаа нь үр дүнтэй арга боловч урт хугацааны шийдэл биш юм. Энэ талаарх явцыг цаашид аудитын тайланд тусгах ба энэ зөрчлийг хаах асуудал цаашид мониторингийн тоо мэдээ ямар гарахаас хамаарна.</p> |
| M1.13 | 13 оны 10-р сар | | Дулааны төв станцын (ДТС) уурын зуухны утаанаас авсан дээж | I | Агаарт ялгарах хийн хаягдлын | Нээлттэй | <p>5.5.3.2 хэсгийг үзнэ үү. ДТС-ын утааны чанарын үзүүлэлт Төслийн стандартад хүрсэн удаа үгүй бөгөөд энэ асуудал байнга тавигдсаар ирсэн. Станцын утаанд хяналт</p> |

ОЮУ ТОЛГОЙ УУРХАЙН ТӨСӨЛ

| Даалгавар/асуудлын дугаар | Уурхайн аудит | Хаасан огноо | Тайлбар | Зөрчил | Лавлах баримт бичиг | Төлөв | Тайлбар/холбогдох тайлан |
|---|--|--------------|--|--------|---|---------|---|
| | 14 оны 4-р сар 14 оны 8-р сар-баримт бичгийн 14 оны 11-р сар 15 оны 4-р сар-баримт бичгийн 15 оны 9-р сар 16 оны 4-р сар-баримт бичгийн 16 оны 8-р сар 17 оны 5-р сар 17 оны 10-р сар 18 оны 9-р сар 19 оны 5-р сар-баримт бичгийн | | төслийн стандартыг хангаж чадахгүй байна. | | менежментийн төлөвлөгөө Агаарын чанарын хяналт шинжилгээний төлөвлөгөө | | шинжилгээ хийсэн хөндлөнгийн байгууллагын дүгнэлтээр утаанаас дээж авахад хэрэглэж байгаа аргачлалд хэд хэдэн дутагдалтай тал байгааг илрүүлсэн. Хийн ялгарлын хяналт шинжилгээний асуудлыг шийдэхийн тулд төсөл саяхан 130 МВт-ын Дулааны төв станцын (ДТС) утаа гардаг үндсэн яндан дээр Утааны тогтмол хяналт шинжилгээний систем (УТХШС) суурилуулсан. УТХШС-ийг дөнгөж саяхан (2019 оны 5-р сард) суурилуулсан бөгөөд энэ тайланг бичих үед ашиглалтад оруулахаар төлөвлөж байсан. Яваандаа УТХШС-ээс авсан тоо мэдээ нь ДТС-ийн утааны чанарыг илүү бодитой үнэлэх, улмаар Төслийн стандарттай харьцуулах боломж бүрдүүлнэ гэж үзэж байна. ОТ Төслийн стандарттай нийцсэн сүүлийн үеийн шилдэг технологи ашиглаж байгаань батлагдсан тул энэхүү зөрчлийг 1-р ангиллын зөрчилд хэвээр үлдээж байна. Гэхдээ ашиглалтад оруулахаар төлөвлөж буй УТХШС-с гарч ирэх тоо мэдээ нь 2017-001 тоот Өөрчлөлтийн мэдэгдлийн дагуу батлагдсан Төслийн шинэчилсэн стандартын тоон үзүүлэлтийг хангахуйц байж чадах эсэхийг хүлээж байна. |
| Байгаль орчин – Биологийн олон янз байдал ба экологийн менежмент | | | | | | | |
| M11.2 | 18 оны 4-р сар | | Ховор ургамлын зүйлд нөлөөлөл үзүүлэхээс сэргийлэх | II | Газар хөндөх зөвшөөрөл аах журам; | Нээлтэй | 5.9.2.3 хэсгийг үзнэ үү. ОТ-н БОННБҮ-ний биологийн олон янз байдлын удирдлага ба нөлөөллийг бууруулахтай холбоотой үүрэг амлалтад заасны дагуу ОТ нь төслийн нөлөөлөлд өртсөн хэсэгт ургадаг дөрвөн зүйл ховор |

ОЮУ ТОЛГОЙ УУРХАЙН ТЭСӨЛ

| Даалгавар/асуудлын дугаар | Уурхайн аудит | Хаасан огноо | Тайлбар | Зөрчил | Лавлах баримт бичиг | Төлөв | Тайлбар/холбогдох тайлан |
|---------------------------|---|--------------|---------|--------|----------------------|-------|---|
| | 18 оны 9-р сар 19 оны 5-р сар - баримт бичгийн | | | | БОЯБУАТ; БОЯБХШҮТ | | <p>ургамалд эерэг нөлөө ахиу үзүүлэх үүрэгтэй. Төслийн нөлөөлөлд өртсөн хэсэг нь тэдгээр зүйлүүдийн Чухал амьдрах орчинд тооцогддог ба Байгалийн амьдрах орчин нь болж өгдөгтэй холбоотойгоор өөр дөрвөн зүйл ургамалд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх үүрэгтэй.</p> <p>Нөлөөллийг бууруулах шатлалын дагуу а) Одоо байгаа ургамал, амьдрах орчныг хөндөхөөс зайлсхийх, хамгаалах (нөлөө үзүүлэхээс зайлсхийх) б) Нөлөө үзүүлэхээс зайлсхийх боломжгүй бол тухайн ургамлыг шилжүүлэн суулгах (хэрэв тухайн ургамал амьдрах чадвартай гэж үзвэл) с) үр эсвэл суулгацаас шинээр үржүүлэг хийж, дахин өөр тохиромжтой байршилд суулгах замаар нөхөн сэргээх d) судалгаа хийх гэсэн шат дарааллаар эерэг нөлөөлөл ахиуц үзүүлэх үүрэгтэй.</p> <p>2018 оны 5-р сард хийсэн аудитаар БОНХЗ нь ховор ургамлын зүйлд (тодруулбал <i>Spongiocarpella grubovii</i> буюу <i>Грубовын хөөндэй</i>) үзүүлж буй нөлөөлөлтэй холбоотойгоор III ангиллын зөрчил гэж тодорхойлсон. Энэ зүйл ургамлыг үржүүлэх, шилжүүлэн суулгах, нөхөн сэргээх ажлыг амжилттай хийх боломжтойг нотолсон баримт байхгүй байгаа нь зээлдүүлэгчдийн шаардлагыг (ГС6, ГШ6) хангахуйц хэмжээнд эерэг нөлөөлөл ахиу үзүүлнэ гэсэн баталгааг байхгүйн илрэл юм. Грубовын хөөндэй(<i>S.grubovii</i>)-н үр соёолуулах туршилтыг 2019 оны хавар/зун эхлүүлэх төлөвлөгөөтэй байгаа. Гэхдээ ОТ энэ зүйл ургамлыг үржүүлэхэд чиглэсэн ажилд ач холбогдол өгч, эдээс үржүүлэх туршилт хийж, үндэслэсэн зэрэг тодорхой хэмжээний ахиц гаргасныг БОНХЗ хүлээн зөвшөөрч байна. Тиймээс БОНХЗ энэ зөрчлийг II түвшний зөрчил болгож бууруулсан. Гэсэн ч эдгээр зүйл ургамлуудад эерэг нөлөөлөл ахиу үзүүлэх боломжтойг батлах харуулах гол хүчин зүйл гэдэг утгаараа <i>S. Grubovii</i> буюу Грубовын хөөндэйг үржүүлэх боломжтойг талбайн туршилтаар харуулах хүртэл энэ зөрчлийг хэвээр үлдээж байна. ГС6, ГШ6 зэрэг Зээлдүүлэгчдийн холбогдох шаардлагуудын дагуу ОТ-н Биологийн олон янз байдлын менежментийн төлөвлөгөөнд энэ чиглэлийн ажлууд тусгагддаг.</p> |

Хүснэгт 3.2-т БОНХЗ 2013 оны 10-р сард уурхайд ирж аудит хийснээс хойш илэрсэн зөрчлүүдийн төлөвийг нэгтгэн харуулав.

Хүснэгт 3-2 БОНХЗ-ийн тогтоосон зөрчлийн статус

| Даалгаврын д/д | Уурхайд хийсэн аудит | Шинээр илрүүлсэн зөрчил | Хаагдсан зөрчил | Хаагдаагүй үлдсэн зөрчил |
|----------------|--|-------------------------|-----------------|--------------------------|
| M1 | 2013 оны 10-р сар | 26 | хамаарахгүй | хамаарахгүй |
| M2 | 2014 оны 4-р сар | 11 | 8 | 29 |
| M3 | Баримт бичгийн аудит 2014 оны 8-р сар | 2 | 3 | 28 |
| M4 | 2014 оны 11-р сар | 7 | 10 | 25 |
| M5 | Баримт бичгийн аудит 2015 оны 4-р сар | 0 | 3 | 22 |
| M6 | 2015 оны 9-р сар | 4 | 6 | 20 |
| M7 | Баримт бичгийн аудит 2016 оны 4-р сар | 1 | 9 | 12 |
| M8 | 2016 оны 8-р сарын 14 | 4 | 2 | 14 |
| M9 | 2017 оны 5-р сар | 1 | 6 | 9 |
| M10 | Баримт бичгийн аудит 2017 оны 10-р сар | 0 | 3 | 6* |
| M11 | Баримт бичгийн аудит 2018 оны 4-р сар | 1 | 3 | 4 |
| M12 | 2018 оны 9-р сар | 1 | 1 | 3 |
| M13 | Баримт бичгийн аудит 2019 оны 5-р сар | 1 | 1 | 4 |